



МАЛ БҮХИЙ ХОРООДЫН  
ЗАСАГ ДАРГА НАРТ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны III байр  
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09  
E-mail: ub\_info@inspection.gov.mn  
http://www.ub.inspection.gov.mn

2017.02.10 № 02-01/531  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Мал аж ахуй эрхлэхийг хориглосон  
бүсээс мал гаргах тухай

Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 2017 он гарсаар Налайх дүүрэгт малын гоц халдварт цэцэг өвчин, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт мал, амьтны галзуу өвчин оношлогдон тухай дүүргүүдэд Засаг даргын захирамжаар хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосонтой холбогдуулан Нийслэлийн нутаг дэвсгэрт өвчний халдвар дамжин тархах болзошгүй эрсдэл үүссэн байна.

Иймд Монгол Улсын Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.3, 4.5.4, 4.5.8, 4.5.10 дах заалтууд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 85 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх журам"-ын 4.1, 6.9, 6.10, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам"-ын 6.12 дах заалтуудын дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1. Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд байршиж буй мал амьтны тоо судалгааг гаргаж, сууршлын бүсээс нүүлгэн шилжүүлэх
2. Хорооныхоо нутаг дэвсгэрт хөдөө орон нутгаас мал, амьтан ирж нутаглах, зусах, намаржихыг хориглох;
3. Өвчний голомт болон сэжигтэй бүс нутгаас мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нийслэлийн нутаг дэвсгэрт болон бусад аймаг, суманд тээвэрлэх, худалдахыг өвчний дэгдэлт, тархалтыг бүрэн зогсох хүртэл хугацаанд хориглох;
4. Мал, амьтны халдварт өвчнөөр болон зүй бусаар үхэж хорогдсон малын сэг, зэм цуглуулж, устгах, өвөлжөө, хаваржаа, өтөг бууц, хашаа саравч, малын тоног хэрэгсэлд хийх ариутгал халдваргүйтгэлийг орон нутгийн мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх;
5. Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, зориулалтын бус ажлын байранд айраг, сүү цагаан идээ, түүхий мах /ууц, өвчүү, тураг мах/ худалдаалахыг хориглох;

Монгол Улсын Малын удмын сан эрүүл мэндийн хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх "Малын өвчинтэй тэмцэх, удмын санг хамгаалах ажлыг зохион

1150500544

байгуулахад төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэр, дүрэм, журмыг биелүүлэх” заалтыг зөрчсөн хуулийн этгээд, албан тушаалтанд хариуцлага тооцохыг мэдэгдье.

ДАРГА



Л.ЭРДЭНЭЧУЛУУН